



**УЛСЫН ЧАНАРТАЙ АВТО ЗАМ, ЗАМЫН БАЙГУУЛАМЖИД  
ҮҮССЭН ЭВДРЭЛИЙГ СЭРГЭЭН ЗАСВАРЛАХ  
АЖЛЫН ГЭРЭЭ**

2022 оны 07 дугаар  
сарын 06 ны өдөр

Дугаар 222

Улаанбаатар хот

Нэг талаас Зам, тээврийн хөгжлийн яам /цаашид “захиалагч” гэх/ нөгөө талаас “Дундговь авто зам” ХХК /цаашид “гүйцэтгэгч” гэх/ нар Монгол Улсын Иргэний хууль, Авто замын тухай хууль болон бусад хууль тогтоомжийн хүрээнд харилцан тохиролцож, Засгийн газрын тогтоол, Зам, тээврийн хөгжлийн сайдын тушаалаар батлагдсан улсын чанартай авто зам, замын байгууламжид үүссэн эвдрэлийг сэргээн засварлах ажлыг гүйцэтгүүлэхээр энэхүү гэрээг байгуулав.

**НЭГ.Гэрээний ерөнхий нөхцөл.**


1.1 Монгол Улсын Иргэний хууль, Авто замын тухай хууль болон бусад хууль тогтоомжийн дагуу улсын чанартай авто зам, замын байгууламжид үүссэн эвдрэлийг саатлыг арилгах, сэргээн засварлах ажлыг гүйцэтгэхтэй холбогдон захиалагч, гүйцэтгэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний /цаашид “гэрээ” гэх/ зорилго оршино.

1.2 Ажил гүйцэтгэгч нь Засгийн газрын 2022 оны 233 дугаар тогтоол, Зам, тээврийн хөгжлийн сайдын 2022 оны А/190 дүгээр тушаалаар батлагдсан хөрөнгөнд багтаан улсын чанартай авто зам, замын байгууламжид үүссэн эвдрэлийг сэргээн засварлан автотээврийн хэрэгсэл саадгүй зорчиход бэлэн болгох үүргийг хүлээнэ.

1.3 Энэхүү гэрээгээр нь улсын чанартай авто зам, замын байгууламжид үүссэн эвдрэлийг сэргээн засварлах ажлын төсөвт өртөг, чанар, хугацааг эцэслэн тохирно.

1.4 Улсын чанартай авто зам, замын байгууламжид үүссэн эвдрэлийг сэргээн засварлах ажил нь дараах хүснэгтэд заагдсан ажил байна.

| №   | Замын дугаар | Замын чиглэл           | Хийгдсэн ажлын нэр, байршил   | Зарцуулах хөрөнгө /төгрөг/ |
|-----|--------------|------------------------|---|----------------------------|
| 1   | A0202        | Мандалговь-Даланзадгад | Уг чиглэлийн авто замын 85-105 км-т хучилтын нийт 12118 м2 нүхэн эвдрэлийг халуун асфальтбетоноор засварлах                   | 3,003,797,448.0            |
| 2   | A0202        | Мандалговь-Даланзадгад | Уг чиглэлийн авто замын 85-105 км-т хэсэгчилсэн нийт 5,048 км замын суурийг цементээр бэхжүүлэн 5 см асфальтбетон хучилт хийх |                            |
| Дүн |              |                        |   | 3,003,797,448.0            |



1.5 Гэрээний дүн 3,003,797,448.0 /Гурван тэрбум гурван сая долоон зуун ерэн долоон мянга дөрвөн зуун дөчин найм/ төгрөг болно.

1.6 Энэхүү гэрээ нь 2022 оны 12 дугаар сарын 31-нийг дуустал хүчинтэй байна.

### **ХОЁР. Захиалагчийн эрх үүрэг**

2.1 Улсын чанартай авто зам, замын байгууламжид үүссэн эвдрэлийг сэргээн засварлах ажилд тавих хяналтыг захиалагч, түүний итгэмжлэгдсэн төлөөлөгч /цаашид "захиалагчийн төлөөлөгч" гэх/ гүйцэтгэнэ.

2.2 Ажлын гүйцэтгэлийг захиалагчийн баталгаажуулсан маягтын дагуу эрх бүхий албан тушаалтнууд баталгаажуулах бөгөөд гүйцэтгэлийг шалгах явцад БНБД, стандарт, техникийн шаардлагыг зөрчиж хийсэн ажлын гүйцэтгэлийг санхүүжүүлэхгүй буцаах бөгөөд зөрчлийг арилган ажлын гүйцэтгэлийг дахин ирүүлсэн тохиолдолд гүйцэтгэлийг хянаж, баталгаажуулан санхүүжүүлэх хугацааг дахин шинээр тооцох ба үүнээс шалтгаалан гарсан хохирлыг захиалагч хариуцахгүй.

2.3 Авто зам, замын байгууламжид үүссэн эвдрэлийг сэргээн засварлах ажлыг хянаж шалгахдаа "Авто зам, замын байгууламжийн арчлалт, засварын зохион байгуулалтын техникийн дүрэм" /ЗЗБНБД 41-011-2016/, "Авто зам, замын байгууламжийн арчлалт, урсгал засвар, онцгой ажлуудыг гүйцэтгэх хугацааны норм" /ЗЗБНБД 41-010-2016/, "Авто зам, замын байгууламжийн засвар, арчлалтын техникийн шаардлага", Төсөв зохиох заавар, Төсвийн норм үнэлгээнүүдийг үндэслэл болгоно.

2.4 Урьдчилгаа санхүүжилт нь гэрээний үнийн дүнгийн 50 хувь байх бөгөөд санхүүжилтийг голлох түүхий эд болох битум, асфальт хольц, цемент, шатахуун худалдан авах, механизмын түрээсэнд зориулна. Урьдчилгаа төлбөрийг энэхүү зориулалтаас өөрөөр ашиглахыг хориглоно. Урьдчилгаа төлбөрийг хийсэн ажлын гүйцэтгэлээс суутган тооцно.

2.5 Авто зам, замын байгууламжид үүссэн эвдрэлийг сэргээн засварлах ажлын чанар аюулгүй байдлыг захиалагч, захиалагчийн төлөөлөгч газар дээр нь үзэж шалгана. Шаардлагатай тохиолдолд захиалагчийн зүгээс баталсан удирдамжийн дагуу ажлын хэсэг ажлын явц, чанар, аюулгүй байдалд шалгалт хийж, гарсан дүгнэлтийг үндэслэн холбогдох арга хэмжээг авах эрхтэй.

2.6 Захиалагч, захиалагчийн төлөөлөгч нь авто зам, замын байгууламжид үүссэн эвдрэлийг сэргээн засварлах ажилтай холбогдох ажлын талбай дээрх заавар, зөвлөмжийг албан ёсоор /бичгээр/ гүйцэтгэгчид өгч хэрэгжилтэд нь хяналт тавих бөгөөд энэ зөвлөмжийн нэг хувийг гүйцэтгэгчид өгч хадгалуулсан байна.


2.7 Гэрээгээр хүлээсэн үүргээ хангалтгүй, эсхүл биелүүлээгүй нь хууль тогтоомж, холбогдох дүрэм, журам, стандартаар батлагдсан тохиолдолд Захиалагч гэрээг дангаар цуцлах эрхтэй.

### **ГУРАВ. Гүйцэтгэгчийн эрх, үүрэг.**

3.1 Авто зам, замын байгууламжид үүссэн эвдрэлийг сэргээн засварлах ажлыг холбогдох норм, дүрэм, стандарт, журмыг баримтлан, гэрээнд заасан хугацаа, хөрөнгийн хэмжээнд багтаан техникийн шаардлагын дагуу гүйцэтгэж, авто замын байнгын бэлэн байдлыг хангах үүрэгтэй.

3.2 Гүйцэтгэгч гэрээнд заасан үүрэг, хариуцлагыг ханган ажиллахын тулд ажлын явцад дотоодын хяналт, шалгалтыг тогтмол хийж гүйцэтгэнэ. Хяналт шалгалтыг тодорхой удирдамжийн дагуу туршлагатай мэргэшсэн мэдлэг, ур чадвартай, хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны чиглэлээр тодорхой мэдлэгтэй хүнээр гүйцэтгүүлнэ.

3.3 Эвдрэлийг сэргээн засварлах ажлын үе шат бүрийг огноо бичиж байршил заасан самбар, тэмдэг болон тухайн байдал, орчинг харуулсан фото зураг, захиалагчийн төлөөлөгчийн



дүгнэлт болон бусад шаардлагатай баримтаар баталгаажуулан гүйцэтгэлийг цаг хугацаанд нь үнэн зөв бичиж захиалагчид ирүүлнэ.

3.4 Авто зам, замын байгууламжид хийсэн засварын ажлын баталгаа нэг жил байх бөгөөд энэ хугацаанд гүйцэтгэгчийн буруугаас болж эвдрэл, гэмтэл гарвал гүйцэтгэгч өөрийн хөрөнгөөр засварлан хүлээлгэж өгнө.

3.5 Авто замд үүссэн эвдрэлийг сэргээн засварлах ажил гүйцэтгэхдээ авто зам, замын байгууламжийн хөдөлгөөний аюулгүй байдлыг ханган, зам хэрэглэгчдийг тав тухтай зорчих нөхцөлийг хангахад онцгой анхаарч ажиллах бөгөөд авто зам, замын байгууламжийн бэлэн болон ашиглалтын байдалд үнэлэлт дүгнэлт өгч захиалагчийг мэдээллээр тогтмол хангах үүрэгтэй.

3.6 Хянаж баталгаажуулахаар ирүүлсэн ажлын тоо хэмжээ, үнэн бодит бичигдсэн эсэхийг тухайн гүйцэтгэгч компани захиалагч, захиалагчийн төлөөлөгчийн өмнө бүрэн хариуцах бөгөөд санхүүжилтийн тооцоог гэрээт хугацаанд багтаан захиалагчтай нийлж актаар баталгаажуулна.

#### **ДӨРӨВ. Захиалагч, гүйцэтгэгчийн хүлээх хариуцлага**

4.1 Төрийн нарийн бичгийн даргын тушаалаар батлагдсан "Ажлын хэсэг" гүйцэтгэгч талыг байлцуулан гэрээг дүгнэнэ.

4.2 Энэхүү гэрээнд заасан үүргээ биелүүлээгүйгээс үүдэн гарах хариуцлагыг буруутай тал нь хариуцна.

4.3 Гүйцэтгэгч нь гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй буюу ажилдаа алдаа, дутагдал, зөрчил, доголдол гаргасан бол захиалагч мэдэгдэл өгч, тодорхой заасан хугацаанд гаргасан алдаа, дутагдал, зөрчил, доголдлыг засч үүргээ биелүүлэхийг шаардана.

4.4 Захиалагч болон Гүйцэтгэгч нь гэрээгээр хүлээсэн үүргээ хугацаанд нь гүйцэтгэж чадаагүй бол хугацаа хэтрүүлсэн хоног тутамд гүйцэтгээгүй ажлын үнийн дүнгийн 0.25 хувиар буруутай талдаа алданги ногдуулна. Алданги ногдуулснаар тухайн ажлыг гүйцэтгэх үүргээс чөлөөлөгдөхгүй. Алдангийн нийт дүн гэрээний үнийн дүнгийн 10 хувиас хэтэрч болохгүй бөгөөд хэтэрсэн тохиолдолд буруугүй тал нь гэрээг цуцлах үндэслэл болно.

4.5 Авто зам, замын байгууламжид үүссэн эвдрэлийг сэргээн засварлах ажлын чанар байдлыг шалгах явцад гэрээт ажлаа хийгээгүй болон чанаргүй гүйцэтгэсэн, авто зам, замын байгууламжийн бэлэн байдлыг бүрэн хангаж чадаагүй гүйцэтгэгч, холбогдох албан тушаалтан зохих хууль, дүрэм, журмын дагуу хариуцлага хүлээнэ.

4.6 Гаргасан алдаа, зөрчил, доголдлыг заасан хугацаанд арилгаж үүргээ биелүүлээгүй, ажил гүйцэтгэхээс татгалзсан, дампуурсан, эсхүл татан буугдах талаар эрх бүхий байгууллагын шийдвэр гарсан бол Захиалагч нь Гүйцэтгэгчид гэрээ цуцлах талаар мэдэгдэл өгснөөс хойш 3 хоногийн дараа гэрээ цуцлагдана.

4.7 Гэрээг цуцлах захиалагчийн шийдвэр нь гэрээний дагуу хүлээсэн Захиалагчийн бусад эрх, үүрэгт нөлөөлөхгүй.


#### **ТАВ. Маргаан шийдвэрлэх**

5.1 Энэхүү гэрээг биелүүлэхтэй холбогдон гарсан аливаа санал маргаан, зөрөлдөөнийг талууд зөвшилцөх аргаар шийдвэрлэхийг эрмэлзэнэ.

5.2 Маргаан, зөрөлдөөнийг шийдвэрлэх боломжгүй тохиолдолд Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу шүүхээр шийдвэрлүүлнэ.

#### **ЗУРГАА. Бусад**

6.1 Энэхүү гэрээ нь талуудын эрх бүхий төлөөлөгчид гарын үсэг зурж баталгаажуулснаар хүчин төгөлдөр болно.



6.2 Энэхүү гэрээг 4 хувь үйлдэж Зам, тээврийн хөгжлийн яам, Гүйцэтгэгч тус бүр хадгална.

6.3 Гэрээтэй холбоотой бүхий л мэдээлэл, мэдэгдэл, албан бичгийг дараах хаягаар хүргүүлнэ. Хаяг өөрчлөгдсөн тохиолдолд мэдэгдэх нь талуудын үүрэг ба ийнхүү мэдээлээгүйгээс мэдэгдэл, албан бичиг хүрээгүйн хариуцлагыг тэдгээрийн хүргүүлсэн тал хариуцахгүй болно.

### ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

#### ЗАХИАЛАГЧ:

АВТО ЗАМЫН БОДЛОГЫН  
ХЭРЭГЖИЛТИЙГ ЗОХИЦУУЛАХ  
ГАЗРЫН ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР  
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Б.ОЮУНДЭЛГЭР

БОДЛОГО ТӨЛӨВЛӨЛТИЙН ГАЗРЫН  
САНХҮҮ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН  
ХЭЛТСИЙН ДАРГА

Ч.РЕНЧИНДАМБА

ЗАМЫН АШИГЛАЛТ ЗАСВАРЫН  
ХЭЛТСИЙН ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР  
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Ч.СУГАРМАА

ЗАМЫН АШИГЛАЛТ ЗАСВАРЫН  
ХЭЛТСИЙН ШИНЖЭЭН

Н.СУГАРЖАВ

#### ХЯНАСАН:

ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН  
ГАЗРЫН ХУУЛИЙН ХЭЛТСИЙН ДАРГА

Н.БАТ-ЭРДЭНЭ

ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН  
ГАЗРЫН ХУУЛИЙН ХЭЛТСИЙН  
МЭРГЭЖИЛТЭН

Д.ОЮУНСҮРЭН

#### ХАЯГ:

Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг  
Чингисийн өргөн чөлөө -11  
Зам, тээврийн хөгжлийн яам  
Банк: Төв төрийн сан  
Дансны дугаар: 900028306  
Регистрийн дугаар. 5919487  
Утас: 62263207, 62263193  
Факс: 312315

#### ГҮЙЦЭТГЭГЧ:

“ДУНДГОВЬ АВТО ЗАМ” ХХК-  
ИЙН ЕРӨНХИЙ ИНЖЕНЕР

В.АЗЖАРГАЛ

ЕРӨНХИЙ САНХҮҮЧ



Ж.БУРМАА

#### ХАЯГ:

Дундговь аймаг Сайнцагаан сум  
7-р баг, Бага тойруу 32 байр 303

Банк: Хаан банк  
Дансны дугаар: 5622442867  
Регистрийн дугаар: 6069282  
Утас: 99996832, 98111959  
Факс:

